



2017 оны 01 дүгээр сарын 06-нд

**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**


№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа
Нэг.Хорооны дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт			
1	Ёс зүйн хорооны дотоод зохион байгуулалтын ажлыг хэлэлцэх, 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөөг танилцуулах.	Ёс зүйн хорооны дарга Ш.Чинбат	01 дүгээр сарын 15-дын дотор
2	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг гаргах.	Ёс зүйн хорооны нарийн бичиг Э.Баяржаргал	06 дугаар сарын 10 12 дугаар сарын 10
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын бүртгэл хөтлөх.	Ёс зүйн хорооны нарийн бичиг Э.Баяржаргал	Тухай бүр
4	Ёс зүйн хорооны хурлыг товлосон хугацаанд зохион байгуулах, үйл ажиллагааны тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.	Ёс зүйн хорооны нарийн бичиг Э.Баяржаргал	Тухай бүр
Хоёр.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх			
5	Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулах.	Ёс зүйн хороо	02 дугаар сарын 10-ны дотор
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах.	О.Сэлэнгэ Б.Болормаа	Жилдээ
7	“Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинээр томилогдсон албан тушаалтанд	Б.Болормаа	Тухай бүр

	тухай бүр танилцуулж, баталгаажуулах.		
8	Эерэг хандлага, стресс тайлах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулах, зурагт хуудас байршуулах.	Ёс зүйн хороо	Жилдээ
Гурав. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны ил тод байдал			
9	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдон гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах, хууль тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх, байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулах.	Ёс зүйн хороо	Тухай бүр
10	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлтийг цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулах.	Ёс зүйн хорооны дарга Ш.Чинбат	1 дүгээр улирал Хагас, бүтэн жил
11	Ёс зүйн хорооноос зохион байгуулсан үйл ажиллагааны талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах.	Ёс зүйн хороо	Тухай бүр
12	Төрийн албанд мөрдөгдөх хууль тогтоомжийг зөрчсөн нь илэрсэн болон албан тушаалаа урвуулан ашигласан байж болох нөхцөлд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд яаралтай мэдээлэх.	Ёс зүйн хороо	Тухай бүр

БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ХОРООНЫ НАРИЙН

БИЧИГ

 Э.БАЯРЖАРГАЛ